

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

Агуулга.....	1
1.Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татварын тухай хууль
НДШТ	Нийгмийн Даатгалын Шимтгэлийн тайлан
ТҮГ	Төсөвт Үйлдвэрийн газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БУЯНТ-УХАА ДАХЬ ГААЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА С.ЦЭЦГЭЭ  
ТАНАА

2020.02.27 № 06/637  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Буянт-Ухаа дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Буянт-ухаа дахь гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Буянт-ухаа дахь гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус музейд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал С.Цэцгээ Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн бараа материалын тайланг үнэн зөв гаргаж байх, үндсэн хөрөнгө, шатахууны зардал, цалин хөлсийг үнэн зөв тооцож байх, холбогдох хууль журам зааврыг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 10-наас 2020 оны 02 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, "Голден пэйж аудит" ХХК-ийн захирал С.Оюунгэрэл хянан удирдаж, аудитор Я.Оюун, Б.Дашням хариуцаж хэрэгжүүлэв.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний Аудитын Газарт 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 01/84 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Буянт-Ухаа дахь гаалийн газар нь “Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын үйл ажиллагааны чиглэл:

- Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх
- Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хууль бус барааны эргэлттэй тэмцэх чадавхыг дээшлүүлэх
- Тарифын зохистой бодлого хэрэгжүүлэх, улсын төсвийн орлогыг бүрэн дүүрэн бүрдүүлэх
- Гаалийн байгууллагын чадавхыг дээшлүүлэх, мэргэшсэн, өндөр ур чадвартай боловсон хүчнээр хангах, хүний нөөцийг чадавхийг хөгжүүлэх
- Гаалийн байгууллагад өөрчлөлтийн менежмент, сайн засаглалыг хэрэгжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлэх
- Хилийн хяналтыг зохицуулах менежментийг хэрэгжүүлэх, бараа тээврийн хэрэгслийн урсгалыг саадгүй болгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд “нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ”;
- Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлд “нийтээр амрах баярын өдөр”;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлд “албан татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх” гэсэн заалтуудад тус тус өөрчлөлт орсон байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Буянт-Ухаа дахь гаалийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Юникус программ хангамж ашиглаж байна.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Буянт-Ухаа дахь гаалийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 25 эрсдэлтэй асуудалд 25 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны хагас жилийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд хагас жилийн дүнгээс сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,804,643.1 мянган төгрөгөөс тооцон 36,092.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт болох жилийн эцсийн нийт зардал 3,606,816.4 мянган төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 72,136.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 72,136.3 мянган төгрөгөөр тооцсон нь өмнөх оны аудитад материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2.0 хувиар тооцсон нь тухайн байгууллагын хувьд эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 115,418.5 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	385.1	886.0	(500.9)
Бараа материал	75,969.8	118,620.0	(42,650.3)
Үндсэн хөрөнгө	1,895,094.2	1,736,524.4	158,569.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,971,449.0</b>	<b>1,856,030.4</b>	<b>115,418.5</b>
Өр төлбөр	531.8	469.8	62.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,970,917.2	1,855,560.6	115,356.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,971,449.0</b>	<b>1,856,030.4</b>	<b>115,418.5</b>

Авлага дансны үлдэгдэл 500.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хувь хүмүүсээс авах авлагатай холбоотой. Дээрх авлагыг 2019 оны жилийн эцсийн тайлангаар бүрэн тооцоо нийлж баталгаажуулсан.

Бараа материалын дансанд холбогдох журам, нормативыг үндэслэн 148,118.7 мянган төгрөгийн бараа материал орлогодсноос 57,597.6 мянган төгрөгийн бараа материал нь Гаалийн ерөнхий газраас шилжиж ирсэн ба 105,468.4 мянган төгрөгийн бараа материал зарлагадаж 118,620.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд 6,599.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 158,569.7 мянган төгрөгөөр буурсан нь Гаалийн ерөнхий газраас 352,251.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжин ирж, 46,300.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 464,850.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ. Хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө байхгүй байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 62.1 мянган төгрөгөөр буурсан. Өглөгийг 2019 оны жилийн эцсийн тайлангаар бүрэн тооцоо нийлж баталгаажуулсан.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Буянт-Ухаа дахь гаалийн газар нь доорх орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт

/мянган төгрөг/				
№	Орлого	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Татвар	101,583,650.00	106,205,290.20	104.5
2	Хураамж	236,080.00	172,355.40	73.0
3	Өөрийн орлого	449,330.00	1,073,764.70	239.0
	<b>Нийт</b>	<b>102,269,060.00</b>	<b>107,451,410.30</b>	<b>105.07</b>

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 3,120,490.6 мянган төгрөгийн урсгал зардлын төсөв батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардалд 3,120,490.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс 10,000.0 мянган төгрөгийн нэмэлт төсвийн санхүүжилтийг авч мэдээллийн самбар хийлгэж байршуулсан, 3,130,050.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 439.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 25 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 25 эрсдэл тодорхойлж нийт 25 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн нийт 37,866.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, Менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цахим баримтын бүрдүүлэлтийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

Буянт-ухаа дахь гаалийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 123 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,612.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 1,623.5 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлж, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.



#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Буянт-Ухаа дахь гаалийн газар нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Анхан шатны баримттай холбоотой асуудал

- 3.1.1. Илрүүлэлт: Цахим баримтын бүрдэлийг ханган ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5 “Төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих” заалтыг тус тус зөрчсөн.
- 3.1.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомж хэрэгжихгүй байх;
- 3.1.3. Өгсөн зөвлөмж: Цахим баримтын бүрдэлийг хангаж ажиллах, цахим баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх;
- 3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Алдааг давтан гаргахгүйгээр худалдан авалт хийсэн гүйлгээ бүр дээр цахим баримт шивүүлэх талаар тухай бүр дээр шаардаж тооцоо нийлэн ажиллана.

#### 3.2 Бараа материалын данстай холбоотой асуудал

- 3.2.1 Илрүүлэлт:
  - Бараа материалын дансанд 22,000.0 мянган төгрөгийн бараа материал Гаалийн ерөнхий газраас шилжиж ирсэн гэх боловч баримт, тогтоол шийдвэргүй, ангилал буруу бүртгэсэн;
  - Бараа материалын тайлангаар сэлбэг хэрэгслийн үлдэгдэл 3,440.5 мянган төгрөг, гүйлгээ балансаар 4,165.5 мянган төгрөг байгаа нь бараа материалын үлдэгдэл 725.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 “анхан шатны баримтыг үндэслэн дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, ажил гүйлгээний мэдээ гаргах, үнэн зөв хураангуйлан дансанд бүртгэх” гэж заасантай нийцэхгүй байна.
- 3.2.2 Эрсдэл: Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр хэрэгжихгүй байх;

3.3.3 Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайланг сар бүр хэвлэн авч, гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулсан тайланг үндэслэн дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, үнэн зөв хураангуйлан дансанд бүртгэх;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- Алдааг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана;
- Хариуцсан бүртгэлийн ажилтан, архивын ажилтны буруугаас өөр бараа материалын тайлан үдэгдсэн, алдааг давтан гаргахгүй.

### **3.3 Шатахууны зардалтай холбоотой асуудал**

3.3.1 Илрүүлэлт: Суудлын авто машины шатахууны зарцуулалт Засгийн газрын 2015 оны 05 дугаар сарын 11-ний 184 тоот тогтоолын хязгаараас 3,440.7 мянган төгрөгөөр илүү байна.

3.3.2 Эрсдэл: Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр хэрэгжихгүй байх;

3.3.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 заалтыг хэрэгжүүлэх;

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тус газрын үндсэн онцлог Улаанбаатар хотод байрлах хилийн гааль гэсэн статустай ганц газар. Мөн түүнчлэн Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал 2019 онд эхний барилга байгууламж ашиглалтанд орж түүнд явагдах Гаалийн ажилтнуудын ажиллах нөхцөлийг бий болгох, гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийг суурилуулах ажлуудаар хотын төвөөс 70 км зайтай Төв аймгийн Сэргэлэн нутагт байрлах Шинэ Улаанбаатар нисэх буудалд ойр ойрхон дуудагдаж ажилласан. Засгийн газар, NUBIA, ашиглалтын өмнөх захиргаа, Япон Монголын хамтарсан New Airport Ulaanbaatar LLC компанийн ажлын хэсгүүдэд газрын дарга, бусад албадын дарга нар өөрсдийн биеэр оролцож хамтран ажилласан.

### **3.4 Цалин хөлстэй холбоотой асуудал**

3.4.1 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 11,700.5 мянган төгрөгийн цалинг тайлагнаагүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;” гэж заасантай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл: Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр хэрэгжихгүй байх;

3.4.3. Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг хэрэгжүүлэх;

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Алдааг давтан гаргахгүй, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>76,354,823.00</u></b>	<b><u>119,505,999.14</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	385,059.00	885,954.30
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	385,059.00	885,954.30
3351	Байгууллагаас авах авлага	385,059.00	362,828.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	75,969,764.00	118,620,044.84
35300	Бэлэн бүтээгдэхүүн	65,486,175.00	87,610,555.84
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,483,589.00	28,009,489.00
35410	Бичиг хэргийн материал	936,000.00	23,635,500.00
35420	Аж ахуйн материал	3,824,260.00	1,036,410.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,000,000.00	2,280,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,723,329.00	1,057,579.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,895,094,173.54</u></b>	<b><u>1,736,524,420.46</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,895,094,173.54	1,736,524,420.46
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,894,953,548.54	1,736,166,295.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,136,328.00	9,136,328.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	5,481,797.04	6,090,885.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	276,331,480.00	446,231,480.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	183,831,480.06	216,698,146.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,594,444,867.31	2,699,739,259.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	946,066,514.68	1,325,712,887.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	236,071,805.00	220,528,360.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	85,651,139.99	90,967,211.84
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	140,625.00	358,125.00
39301	Програм хангамж	3,200,000.00	3,530,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	3,059,375.00	3,171,875.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,971,448,996.54</u></b>	<b><u>1,856,030,419.60</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>531,846.30</u></b>	<b><u>469,774.28</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	531,846.30	469,774.28
<b>413</b>	<b>Өглөг</b>	531,846.30	469,774.28
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	531,846.30	469,774.28
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	364,454.00	-
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	167,392.30	90,423.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,970,917,150.24</u></b>	<b><u>1,855,560,645.32</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,970,917,150.24	1,855,560,645.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	964,525,286.31	964,525,286.31
51101	Өмч: - төрийн	964,525,286.31	964,525,286.31
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,002,733,156.43	887,376,651.51
51210	Өмнөх үеийн үр дүн	1,002,733,156.43	1,002,733,156.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,658,707.50	3,658,707.50
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,971,448,996.54</u></b>	<b><u>1,856,030,419.60</u></b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,428,785,665.86</b>	<b>3,493,929,684.52</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,538,531,665.86</b>	<b>363,928,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,538,531,665.86	363,928,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,537,680,666.37	363,878,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,537,680,666.37	363,878,700.00
120009	Бусад орлого	850,999.49	49,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,890,254,000.00</b>	<b>3,130,001,484.52</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,890,254,000.00	3,130,001,484.52
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,890,254,000.00	3,130,490,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,970,953,424.19</b>	<b>3,606,816,378.64</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,970,953,424.19</b>	<b>3,606,816,378.64</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,853,873,677.44	3,606,816,378.64
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,168,408,443.61	2,552,329,414.73
210101	Үндсэн цалин	1,909,983,857.31	2,230,172,505.61
210102	Нэмэгдэл	187,721,386.30	322,156,909.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	70,703,200.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	263,745,597.27	326,336,252.95
210201	Тэтгэврийн даатгал	177,527,193.69	221,136,793.43
210202	Тэтгэмжийн даатгал	10,777,302.04	16,815,249.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,554,599.83	25,310,274.78
210204	Ажилгүйдлийн даатгал	10,777,302.04	12,614,786.77
210205	Эрүүл мэндийн даатгал	43,109,199.67	50,459,148.12
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	64,200,000.00	81,600,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,350,000.00	8,362,500.00
210304	Байрны түрээс	59,850,000.00	73,237,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,986,494.49	65,086,299.52
210401	Бичиг хэрэг	7,929,059.00	13,467,821.00
210402	Тээвэр, шатахуун	25,377,361.00	35,554,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,203,875.49	1,232,078.52
210404	Ном, хэвлэл	1,256,000.00	8,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	452,475.00	6,071,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,767,724.00	260,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,367,800.00	34,929,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	799,300.00	
210604	Урсгал засвар	23,568,500.00	33,451,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	290,000.00	-
210702	Дотоод албан томилолт	290,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	96,889,627.67	61,388,860.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,267,126.67	34,481,214.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,600,000.00	2,000,000.00

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	4,817,040.00	4,518,586.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,800.00	418,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,090,000.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,604,661.00	19915660.36
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>197,985,714.40</b>	<b>485,145,651.08</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,033,372.00	6,599,648.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,604,800.00	13,695,150.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	193,347,542.40	464,850,853.08
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>117,079,746.75</b>	<b>-</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>117,079,746.75</b>	<b>0.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,079,746.75	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,457,832,241.67</u></b>	<b><u>(112,886,694.12)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>1,457,832,241.67</u></b>	<b><u>(115,356,504.92)</u></b>

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,890,616,828.00</u></b>	<b><u>3,130,490,600.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,890,616,828.00</b>	<b>3,130,490,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,890,254,000.00	3,130,490,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,890,254,000.00	3,120,490,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	362,828.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	362,828.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>2,890,636,428.00</u></b>	<b><u>3,130,490,600.10</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,890,636,428.00</b>	<b>3,130,490,600.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,773,193,853.25</b>	<b>3,130,050,984.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,158,376,747.41	2,564,038,800.00
210101	Үндсэн цалин	1,102,773,628.67	1,389,844,000.00
210102	Нэмэгдэл	733,642,967.74	800,100,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,598,400.00	100,094,800.00
210104	Урамшуулал	255,361,751.00	274,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	273,028,399.68	309,511,400.00
210201	Тэтгэврийн даатгал	190,856,579.33	228,261,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	23,844,720.35	20,312,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,553,900.00	16,249,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,888,500.00	4,062,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,884,700.00	40,624,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	64,200,000.00	81,600,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,350,000.00	11,850,000.00
210304	Байрны түрээс	59,850,000.00	69,750,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,715,075.49	49,953,578.62
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	7,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	28,689,000.00	31,489,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,453,875.49	1,467,678.62
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,000.00	450,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,122,200.00	1,046,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	118,648,898.00	43,345,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	67,787,298.00	2,609,400.00
210602	Тавилга	15,699,600.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	1,486,400.00
210604	Урсгал засвар	33,662,000.00	39,250,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	290,000.00	-
210702	Дотоод албан томилолт	290,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	115,134,732.67	61,503,736.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,995,232.67	33,514,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,600,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,858,140.00	4,470,736.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	409,700.00	370,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	168,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,214,800.00	12,980,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,996,860.00	7,999,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,800,000.00</b>	<b>20,097,670.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,800,000.00	20,097,670.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>117,442,574.75</b>	<b>439,615.48</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>117,442,574.75</b>	<b>489,115.48</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,442,574.75	489,115.48



#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	964,525,286.31	3,658,707.50	(455,099,085.24)	513,084,908.57
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>964,525,286.31</b>	<b>3,658,707.50</b>	<b>(455,099,085.24)</b>	513,084,908.57
C07	Тайлант үеийн үр дүн			1,457,832,241.67	1,457,832,241.67
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>964,525,286.31</b>	<b>3,658,707.50</b>	<b>1,002,733,156.43</b>	1,970,917,150.24
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>964,525,286.31</b>	<b>3,658,707.50</b>	<b>1,002,733,156.43</b>	1,970,917,150.24
D08	Тайлант үеийн үр дүн			(115,356,504.92)	(115,356,504.92)
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>964,525,286.31</b>	<b>3,658,707.50</b>	<b>887,376,651.51</b>	1,855,560,645.32

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,130,490,600.00	3,130,050,984.52	439,615.48	100.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,130,490,600.00	3,130,050,984.52	439,615.48	100.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,130,490,600.00	3,130,050,984.52	439,615.48	100.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,564,038,800.00	2,564,038,800.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	1,389,844,000.00	1,389,844,000.00	0.00	100.0
210102	Нэмэгдэл	800,100,000.00	800,100,000.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	100,094,800.00	100,094,800.00	0.00	100.0
210104	Урамшуулал	274,000,000.00	274,000,000.00	0.00	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	309,511,400.00	309,511,400.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	228,261,900.00	228,261,900.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	20,312,400.00	20,312,400.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,249,900.00	16,249,900.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,062,500.00	4,062,500.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	40,624,700.00	40,624,700.00	0.00	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	81,600,000.00	81,600,000.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	11,850,000.00	11,850,000.00	0.00	100.0
210304	Байрны түрээс	69,750,000.00	69,750,000.00	0.00	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	49,972,500.00	49,953,578.52	18,921.48	100.0
210401	Бичиг хэрэг	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	31,489,000.00	31,489,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,469,100.00	1,467,678.52	1,421.48	99.9
210404	Ном, хэвлэл	8,500,000.00	8,500,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,600.00	450,600.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,063,800.00	1,046,300.00	17,500.00	98.4
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	43,380,000.00	43,345,800.00	34,200.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,880,000.00	2,609,400.00	270,600.00	90.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	1,486,400.00	13,600.00	99.1
210604	Урсгал засвар	39,000,000.00	39,250,000.00	-250,000.00	100.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	61,889,400.00	61,503,736.00	385,664.00	99.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,741,900.00	33,514,000.00	227,900.00	99.3

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,569,100.00	4,470,736.00	98,364.00	97.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	409,700.00	370,700.00	39,000.00	90.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	168,700.00	168,700.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,000,000.00	12,980,000.00	20,000.00	99.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,000,000.00	7,999,600.00	400.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,098,500.00	20,097,670.00	830.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,098,500.00	20,097,670.00	830.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	(49,500.00)	49,500.00	
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	(49,500.00)	49,500.00	

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: 2020.02.17	Аудитын нэр: Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн	Аудитын код: САГ-2020/104/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Буянт-Ухаа дахь гаалийн газар	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Анхан шатны баримт	0	Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	С.Цэцэгээ, Д.Эрдэнэсүх
2	Бараа материал	22,725.0	Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	С.Цэцэгээ, Д.Эрдэнэсүх
3	Шатахууны зардал	3,440.7	Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	С.Цэцэгээ, Д.Эрдэнэсүх
4	Цалин хөлс	11,700.5	Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	С.Цэцэгээ, Д.Эрдэнэсүх
	<b>Дүн</b>	<b>37,866.2</b>			